

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТУШААЛ

2010 оны 7 сарын 30-ны өдөр

Дугаар 460

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1."Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмын 2.6.1 дэх заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, 2.7.5 дахь заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс тус тус эхлэн мөрдсүгэй.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 491 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

4.Банкны өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааны доод хэмжээг 12 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааны доод хэмжээг 6 хувиар тус тус тогтоосугай.

5.Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

ТЭРГҮҮН ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЖАВХЛАН

**БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ, ТҮҮНД
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Банкны тухай хуулийн 16.1.2 дахь заалтад заасан шаардлагыг банк хэрхэн биелүүлж байгааг тооцох зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоож, түүний биелэлтэд хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Банк нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг зохистой харьцааны дараахь шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож ажиллана:

1.2.1. өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт;

1.2.2. төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа;

1.2.3. зээлийн төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа;

1.2.4. гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа.

1.3. Банк нь энэ журмын 1.2-т заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үнэн зөв тооцож, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тогтоон үнэлэлт, дүгнэлт өгөх замаар үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүнээс сэргийлэх арга хэмжээг авна.

1.4. Банк нь өөрийн үйл ажиллагааны бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавин удирдах зорилгоор энэ журмын 1.2-т заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс гадна, эрсдэлийг удирдах бусад нэмэлт дүрэм, журмыг дотооддоо боловсруулан мөрдүүлж болно. Эдгээр дотоод дүрэм, журам нь энэхүү журамд заасан шаардлагад нийцсэн байна.

1.5. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. “*Банкны өөрийн хөрөнгө*” гэдэгт хувьцаат капитал (ердийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа болон халаасны хувьцаа), бусад өмч (нэмж төлөгдсөн хувьцаа, дахин үнэлгээний нэмэгдэл болон хандивын капитал), хуримтлагдсан ашиг, алдагдал, хоёрдогч өглөг болон нийгмийн хөгжлийн сан орно.

“*Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө*” гэдэгт хувьцаат капитал (ердийн хувьцаа, халаасны хувьцаа болон энэ журмын 2.6.5-т заасан шаардлагыг хангасан давуу эрхтэй хувьцаа), цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сан болон хуримтлагдсан ашиг алдагдал, нэмж төлөгдсөн хувьцаа (ердийн хувьцаа) болон хандивын капитал орно.

“*Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө*” гэдэгт хувьцаат капитал дахь энэ журмын 2.6.4-т заасны дагуу нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцогдсоноос бусад давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн хувьцаа (давуу эрхтэй хувьцаа), дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан, энэ журмын 2.6.8-д заасан тохируулгыг

хийсэн банкны активын ерөнхий эрсдэлийн сан болон 5-аас дээш жилийн хугацаатай хоёрдогч өглөг орно.

/Дээрх заалтыг МБЕ-ийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-338 дугаар тушаалаар шинэчлэн найруулсан./

1.5.2. “Өөрийн хөрөнгийн хүрэлцээ” гэж “Банкны тухай хууль”-ийн 3.1.9-т заасан үнэлгээг хэлнэ.

1.5.3. “Өөрийн хөрөнгийн шаардлага” гэж “Банкны тухай хууль”-ийн 3.1.10-т заасан хэмжээг хэлнэ.:

1.5.4. *Хоёрдогч өглөг*” гэж гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хөрөнгө оруулагчдын хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих бөгөөд энэ талаар холбогдох гэрээнд тодорхой заасан байх өрийн бичгийг хэлнэ.

Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг банкныг татан буулгасан, банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулсан, Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахыг хориглоно.

Банк нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдсан эсхүл дампуурсан тохиолдолд банкны активыг худалдаж борлуулсан орлогоос нэхэмжлэгчийн шаардлагыг хангах дарааллын "бусад өглөг" гэсэн төрөлд хоёрдогч өглөгийг хамааруулна.

1.5.5. “Холбогдох этгээд” гэж Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан этгээдийг хэлнэ.

1.5.6. “Банкны эрсдэлийн ерөнхий түвшин”-г “Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь шалган үнэлгээ, дүгнэлт өгөх журам”-ыг үндэслэн тодорхойлно.

1.5.7. “Гадаад валютын ханшийн эрсдэл” гэж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэлийг хэлнэ.

1.5.8. “Гадаад валютын нээлттэй позиц” гэж тэнцлийн гадаад валютын активын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцэлээс үүсч болзошгүй гадаад валютын авлагын нийлбэр болон тэнцлийн гадаад валютын пассивын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцэлээс үүсч болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэрийн цэвэр зөрүүг хэлнэ.

1.5.9. “Гадаад валютын нээлттэй богино позиц” гэж энэ журмын 1.5.8-д заасан цэвэр зөрүү сөрөг утгатай үед тухайн цэвэр зөрүүгийн абсолют утгыг хэлнэ.

1.5.10. “Гадаад валютын нээлттэй урт позиц” гэж энэ журмын 1.5.8-д заасан цэвэр зөрүү эерэг утгатай үед тухайн цэвэр зөрүүгийн абсолют утгыг хэлнэ.

1.5.11. “Гадаад валютын хаалттай позиц” гэж энэ журмын 1.5.8-д заасан цэвэр зөрүү тэг утгатай байхыг хэлнэ.

1.5.12. “Гадаад валютын нээлттэй позицгийн лимит” гэж тухайн нэг гадаад валют

болон нийт гадаад валютын хувьд үүссэн нээлттэй урт, богино позицийг банкны өөрийн хөрөнгөд харьцуулан тогтоосон хязгаарлалтыг хэлнэ.

1.5.13. “Зах зээлийн эрсдэл” гэж гадаад валютын ханш, хүү болон үнийн хэлбэлзлээс алдагдал хүлээх эрсдэлийг хэлнэ.

1.5.14. “Хамгийн их эрсдэл” буюу "Value-at-Risk" (цаашид "VaR" гэх) гэж санхүүгийн бүтээгдэхүүний багцаас тодорхой хугацаанд, тодорхой магадлалтайгаар хүлээж болзошгүй алдагдлын дээд хэмжээг хэлнэ.

1.5.15. “Мэдрэмтгий байдлын шинжилгээ” буюу “stress test” гэж эрсдэлийн хүчин зүйлийн магадлал багатай боловч боломжтой өөрчлөлтийн дүнд хүлээж болзошгүй алдагдлыг тодорхойлох аргачлалыг хэлнэ.

1.5.16. “Буцаан шалгалт” буюу “backtesting” гэж эрсдэлийг тооцоолох загварын илэрхийлэх чадварыг бодит мэдээлэлтэй харьцуулах замаар тодорхойлох аргыг хэлнэ.

1.5.17. “Ахиуц VaR” буюу “marginal VaR” гэж позиц нэг төгрөгөөр нэмэгдэхэд багцын VaR хэдэн нэгжээр өөрчлөгдөхийг харуулсан хэмжигдэхүүнийг хэлнэ.

1.5.18. “Өсөн нэмэгдэх VaR” буюу “incremental VaR” гэж багцад шинэ позиц нэмэгдэхэд VaR хэдэн нэгжээр өөрчлөгдөхийг харуулсан хэмжигдэхүүнийг хэлнэ.

1.5.19. “Хүчин зүйлийн VaR” буюу “component VaR” гэж багцаас нэг позиц хаахад VaR хэдэн нэгжээр өөрчлөгдөхийг харуулсан хэмжигдэхүүнийг хэлнэ.

1.5.20. “Онцгой VaR” буюу “stressed VaR” гэж банкинд 12 сарын хугацаанд томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл учруулсан үеийн түүхэн мэдээлэлд үндэслэн VaR-г үнэлсэн үнэлгээг хэлнэ.

1.5.21. “Санхүүгийн хөрөнгө” гэж мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, эсвэл гэрээний хугацаа дуусахад мөнгөн хөрөнгөд хөрвөх чадвартай биет бус авлагыг хэлнэ.

1.5.22. “Санхүүгийн өр төлбөр” гэж гэрээний хугацаа дуусахад мөнгөн хэлбэрээр төлөх биет бус өглөгийг хэлнэ.

1.5.23. “Үйл ажиллагааны эрсдэл” гэж банкны дотоод хяналтын тогтолцооны дутагдал, ажилтны зүй бус (ёс зүйн зөрчил, техник алдаа гэх мэт) үйл ажиллагаа, мэдээллийн системийн доголдол, осол болон гадаад хүчин зүйлсийн улмаас алдагдал хүлээх эрсдэлийг хэлнэ.

1.5.24. “Банкны системд нөлөө бүхий банк” гэж сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг эзэлж байгаа банкныг хэлнэ.

[/Дээрх 1.5.24 дэх заалтыг МБЕ-ийн 2011 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 726 дугаар тушаалаар нэмсэн./](#)

1.5.25. “Тусгай эрсдэлийн сан” гэж “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.12.16-д заасныг;

[/Дээрх 1.5.25 дэх заалтыг МБЕ-ийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-338 дугаар тушаалаар](#)

нэмсэн./

1.5.26. “Ерөнхий эрсдэлийн сан” гэж “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.12.17-д заасныг;

/Дээрх 1.5.26 дэх заалтыг МБЕ-ийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-338 дугаар тушаалаар нэмсэн./

ХОЁР. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

2.1. Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг дараахь харьцааг үндэслэн тодорхойлно:

2.1.1. өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа

2.1.2. нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа

2.1.3. Шаардлагатай тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар системийн нөлөө бүхий банкинд тавигдах нэмэлт өөрийн хөрөнгийн шаардлага.

/Дээрх 2.1.3. дахь заалтыг МБЕ-ийн 2011 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 726 дугаар тушаалаар нэмсэн./

2.2. Өөрийн хөрөнгийн шаардлагыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

2.3. Тухайн нэг банкны эрсдэлийн ерөнхий түвшин нь банкны системийн дундаж үзүүлэлтээс өндөр байвал Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр тус банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг энэ журмын 2.2-т зааснаас дээгүүр тогтоож болно.

2.4. Энэ журмын 2.6-д заасны дагуу тохируулсан өөрийн хөрөнгийг энэ журмын 2.7-д заасны дагуу тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулж өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг тооцно. Энэхүү харьцаа нь толгой ба охин компани тус бүрээр, мөн тэдгээрийн нэгдсэн тайлан тэнцлээр өөрийн хөрөнгийн шаардлагаас доошгүй байх ёстой.

2.5. Энэ журмын 2.6-д заасны дагуу тохируулсан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг энэ журмын 2.7-д заасны дагуу тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулж нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг тооцно. Энэхүү зохистой харьцаа нь толгой ба охин компани тус бүрээр, мөн тэдгээрийн нэгдсэн тайлан тэнцлээр өөрийн хөрөнгийн шаардлагаас доошгүй байх ёстой.

2.6. Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцохдоо өөрийн хөрөнгийг дараахь байдлаар тохируулна:

2.6.1. Банк болон банкны бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгөд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан байршуулсан хөрөнгийн 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс тус тус хасна;

/Дээрх 2.6.1. дэх заалтыг МБЕ-ийн 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 762 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан./

2.6.2. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө нэгдүгээр зэрэглэлийн өөрийн

хөрөнгөөс хэтрэхгүй.

/Энэ заалтыг МБЕ-ийн 2011 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 726 дугаар тушаалаар хүчингүй болсонд тооцож 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаалаар нэмсэн./

2.6.3. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцох хоёрдогч өглөг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй.

/Энэ заалтыг МБЕ-ийн 2011 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 726 дугаар тушаалаар хүчингүй болсонд тооцож 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаалаар нэмсэн./

2.6.4. урьдчилсан болон дараалсан хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж өөрийн хөрөнгийн бодит дүнг гаргана;

2.6.5. хугацаагүй, ногдол ашгийг хуримтлуулан тооцдоггүй давуу эрхтэй хувьцаа нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд эзлэх хувь нь 15 хувиас хэтрэхгүй байна;

2.6.6. хянан шалгагч үнэлгээний зохистой байдал, зах зээлийн үнийн хэлбэлзэл, яаралтай худалдан борлуулахад хүлээж болзошгүй алдагдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр шаардлагатай гэж үзвэл банкны тодорхой үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасч тооцож болно;

2.6.7. гудвилыг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасч тооцно;

2.6.8. Банк нь эрсдэлээр жигнэсэн активын 1 хувиас ихгүй хэмжээгээр ерөнхий эрсдэлийн сангийн нөөцийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд энэ журмын 2.6.2.-ыг хангахуйц байдлаар оруулан тооцно.

/Дээрх 2.6.8 дахь заалтыг МБЕ-ийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-338 дугаар тушаалаар нэмсэн./

2.7. Эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцоходоо тэнцлийн актив **болон** тэнцлийн гадуур бүртгэлтэй гэрээ, хэлцлийн дагуу бусдын өмнө хүлээж болзошгүй үүргүүдийн “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу тусгай эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн дүнг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан эрсдэлийн хувь хэмжээгээр үржүүлж, гарах нийлбэр дүнг дараахь байдлаар тохируулна:

/Дээрх 2.7 дахь заалтыг МБЕ-ийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-338 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан./

2.7.1. энэ журмын 2.6.1, 2.6.3, 2.6.4, 2.6.5, 2.6.6-д заасан болон бусад залруулгын гүйлгээг активын холбогдох дансуудад хийнэ;

2.7.2. санхүүгийн деривативын зээлтэй адилтган тооцох өртгийг энэ журмын 7 дугаар хавсралтад заасан аргачлалын дагуу тооцно;

2.7.3. Стандарт энд Пурс (Standard & Poors), Мууди (Moody’s), Фич (Fitch) болон бусад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон рейтингийг ашиглан гадаадын банкнаас авах авлагын эрсдэлийн хувь хэмжээ болон гадаадын банкны батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг дараахь хүснэгтийг үндэслэн тооцно.

Стандарт энд Пурс	AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	B- бага	Рейт инг үй
-------------------	-----------	---------	-------------	----------	---------	-------------------

Фич						
Мууди	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
Урт хугацаат авлага (3 сараас дээш)	20%	50%	50%	100%	150%	100%
Богино хугацаат авлага (3 сараас доош)	20%	20%	20%	50%	150%	100%

2.7.4. гадаад валютын ханшийн тэгшитгэлээс хүлээж болзошгүй алдагдлыг “Хамгийн их эрсдэлийн арга”-аар тооцох эрх авсан банк нь энэ журмын 5.13-т заасан дүнг тухайн банкны мөрдөж байгаа өөрийн хөрөнгийн шаардлагын урвуугаар үржүүлэн нэмэх бөгөөд бусад банкны хувьд энэ журмын 5.6-д заасан нийт нээлттэй позицгийн дүнг нэмнэ.

2.7.5. үйл ажиллагааны эрсдэлээс учирч болзошгүй хохирлоос сэргийлэхийн тулд банк нь сүүлийн гурван жилийн татварын өмнөх эерэг ашгийн дунджийн 15 хувийг тухайн банкны мөрдөж байгаа өөрийн хөрөнгийн шаардлагын урвуугаар үржүүлэн нэмнэ.

ГУРАВ. Хөрвөх чадварын эрсдэл

3.1. Банк нь хадгаламж эзэмшигч, харилцагчийн анхны шаардлагаар -төлбөрийг түргэн гүйцэтгэж чадах эсэхийг энэхүү журмын хавсралт 14-ний дагуу тооцно.

[/Дээрх 3.1. дэх заалтыг МБЕ-ийн 2011 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 213 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан./](#)

3.2. Түргэн борлогдох активыг касс дахь бэлэн мөнгө, Монголбанкинд байршуулсан хөрөнгө, бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, үнэт метал, Төв банкны болон Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын баталгаатай хөгжлийн банкны үнэт цаасны дүнгийн нийлбэрээс клирингийн дамжуулалтын саатлын дансдын үлдэгдлийг хасч тооцно. Гэрээний үндсэн дээр хугацаа, хүүгийн хэмжээг тохироогүй, захиран зарцуулах эрх нь шилжин ирээгүй үнэт цаас, Монголбанкнаас банк байгуулах зөвшөөрлийг нь хүчингүй болгосон, татан буугдсан, дампуурсан, бүрэн эрхт төлөөлөгч болон эрх хүлээн авагч томилсон банкнаас авах авлага болон бусад банкинд үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгон барьцаалсан харилцах, хадгаламжийн үлдэгдлийг түргэн борлогдох активт оруулж тооцохгүй.

[/Дээрх 3.2. дахь заалтыг МБЕ-ийн 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 691 дүгээр тушаалаар өөрчлөн найруулсан./](#)

3.3. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцах, хадгаламж, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр болон бусад өр төлбөрийн нийлбэр дүнгээс клирингийн дамжуулалтын саатлын дансдын үлдэгдлийг хасч тооцно.

[/Дээрх 3.3. дахь заалтыг МБЕ-ийн 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 691 дүгээр тушаалаар өөрчлөн найруулсан./](#)

3.4. ТТГЧ-ын үзүүлэлтийг түргэн борлогдох активыг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулж тооцох бөгөөд ТТГЧ-ын зохистой харьцааны доод хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

[/Дээрх 3.4. дэх заалтыг МБЕ-ийн 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 691 дүгээр тушаалаар өөрчлөн](#)

найруулсан./

3.5. Банк нь санхүүгийн авлага, өглөгийн орох, гарах мөнгөн урсгалын төсөөллийг нэг өдөр, долоо хоног (ажлын 5 өдөр) болон нэг сараар төгрөг, валютаар салган гүйцэтгэнэ. Энэхүү төсөөллийг тооцохдоо тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансдын мөнгөн урсгалыг харгалзан үзэж, энэ журмын Хавсралт 6-ын дагуу гүйцэтгэнэ.

ДӨРӨВ. Зээлийн төвлөрлийн эрсдэл

4.1 “Банкны тухай хууль”-ийн 17.1-т заасан хязгаарлалтыг банк хэрхэн биелүүлж байгааг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу тооцно.

4.2. Банкны нэг зээлдэгч, түүнтэй холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтэрсэн тохиолдолд тухай бүрт Монголбанкинд мэдэгдэнэ.

4.3. “Банкны тухай хууль”-ийн 17.3-т заасан хязгаарлалтыг банк хэрхэн биелүүлж байгааг энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу тооцно.

4.4. Банкнаас холбогдох этгээдүүдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалт нь нэг төслийг санхүүжүүлэх зорилгоор ашиглагдаж байгаа эсвэл аль нэг зээлийн зориулалт тодорхой бус байна гэж үзвэл Монголбанк “Банкны тухай хууль”-ийн 17.3-т заасан хязгаарлалтыг тооцохдоо эдгээр зээлийг нэгтгэн тооцож болно.

4.5. Зээлийн газар зүйн байршил, эдийн засгийн салбар, зориулалт, барьцаа хөрөнгө болон батлан даагч аж ахуйн нэгжтэй холбоотой төвлөрлийн эрсдэлийг зохих түвшинд нь барьж байх хязгаарлалтыг банк өөрөө тогтоож, дотооддоо мөрдүүлнэ.

4.6. ~~Журмын 4.1 болон 4.3-т заасан үзүүлэлтийг тооцохдоо “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.16-д зааснаас бусад тохируулгыг хийсний дараах өөрийн хөрөнгийн дүнг ашиглан тооцно.~~

[/Дээрх 4.6 дахь заалтыг МБЕ-ийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-338 дугаар тушаалаар хучингүй болгосон./](#)

ТАВ. Гадаад валютын ханшийн эрсдэл

5.1. Гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлтийг нийт болон тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц тус бүрээр нь тодорхойлно.

5.2. Нэг гадаад валютын актив пассивын зөрүүг тухайн валютын хувьд дор дурдсан зүйлсийн нийлбэрээр тооцно:

5.2.1. Цэвэр спот позиц буюу тэнцлийн гадаад валютын актив, пассивын зөрүү (үүнд хуримтлуулж тооцсон хүүг оруулан тооцно, алтны үнэлгээг гаргахдаа тухайн үеийн спот ханшийг ашиглана);

5.2.2. Тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гадаад валютын форвард, фьючерс болон свопын арилжаатай холбоотой өглөг авлагын зөрүү (үүнд свопын хувьд спот арилжаатай холбоотой хэсгийг нь хасч тооцох бөгөөд ирээдүйд орох, гарах мөнгөн урсгалыг спот ханшаар нь үнэлнэ);

5.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу төлөх нь тодорхой болсон баталгаа, батлан даалт болон бусад тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүргийн сөрөг дүн;

5.2.4. Ирээдүйд хэрэгжих нь тодорхой болсон, тодорхой гэрээ, хэлцлээр баталгаажсан орлого зарлагын гүйлгээний зөрүү;

5.2.5. Гадаад валютын опционы "дельта" суурьтай өртөг.

5.3. Гадаад валютын эрсдэлийн тайланд зөвхөн тайлант үеэс хойш 6 сарын дотор хэрэгжих гадаад валютын деривативууд, батлан даалт, аккредитив, орлого, зарлага болон гадаад валютын опционы дүнг тусгана.

5.4. Тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц нь банкны энэ журмын 2.6-д заасны дагуу тохируулсан өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй байна.

5.5. Нийт нээлттэй позицийг гадаад валют тус бүрийн хувьд тооцсон урт позициудын нийлбэр болон богино позицуудын абсолют нийлбэрийн аль их дүн дээр алтны нээлттэй позицийг абсолют дүнгээр нь нэмж тодорхойлно.

5.6. Нийт нээлттэй позиц нь банкны энэ журмын 2.6-д заасны дагуу тохируулсан өөрийн хөрөнгийн 40 хувиас хэтрэхгүй байна.

5.7. Банк энэ журмын 5.4 ба 5.6-д заасан хязгаарлалтыг хангаж ажиллана. Банк гадаад валютын эрсдэлийг үнэлэх дотоод аргачлал ашиглаж болох ба уг аргачлал нь энэ журамд тусгасан “Хамгийн их эрсдэлийн арга”-д суурилсан байна.

/Дээрх 5.7. дахь заалтыг МБЕ-ийн 2016 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн А-65 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан./

5.8. Монголбанкны Хяналт шалгалтын газар нь дотоод зохион байгуулалтын дараахь шалгуурыг хангасан банкинд “Хамгийн их эрсдэлийн арга”-ыг ашиглах зөвшөөрлийг олгоно:

5.8.1. Банк нь эрсдэлийн удирдлагын асуудлыг хариуцсан бие даасан тусгай нэгжтэй, энэхүү нэгж нь математик, статистик тусгай загварын дагуу зах зээлийн эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлын тооцоог өдөр тутам гаргаж, удирдлагад танилцуулдаг тогтолцоог бий болгосон;

5.8.2. Эрсдэлийн удирдлагын асуудлыг хариуцсан нэгжийн удирдлага нь тухайн эрсдэл бүхий актив, пассив болон тэнцлийн гадуурхи хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байх бөгөөд тусгай загвар болон програм хангамжийн тусламжтайгаар тооцсон эрсдэлийн үнэлгээг арилжааны лимит тогтоох үйл ажиллагаандаа ашигладаг;

5.8.3. Банкнаас эрсдэлийн удирдлагын талаар, ялангуяа ажилтнуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан тусгай дүрэм, журам, заавар, зөвлөмжийг баталсан;

5.8.4. Банкны дотоод аудитын алба нь өөрийн акт материалдаа дараахь зүйлсийг зайлшгүй тусгасан байна:

– эрсдэлийг удирдах үйл ажиллагаатай холбоотой баримтын бүрдэл;

- эрсдэлийг удирдах нэгжийн зохион байгуулалт, эрсдэлийн үнэлгээг хэрхэн ашиглаж байгаа талаар;
- арилжааны болон арын албанаас эрсдэлийн үнэлгээг тогтооход ашиглаж буй загваруудыг, мөн эдгээр загварт орсон өөрчлөлтийг дээд шатны удирдлагаас хэрхэн баталгаажуулж байгаа;
- тухайн загвар нь зах зээлийн эрсдэлийг хэр зэрэг үндэслэлтэй тодорхойлж байгаа;
- удирдлагын мэдээллийн системийн найдвартай байдал;
- тооцоо судалгаанд ашиглагдаж буй мэдээллийн үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн байдал;
- эрсдэлийн үнэлгээ тогтооход ашиглаж буй мэдээллийг авч байгаа байгууллагын бие даасан байдал болон мэдээлэл нь найдвартай бөгөөд цаг хугацаандаа ирж байгаа эсэх;
- ханшийн хэлбэлзэл, ханшийн хоорондын хамаарлыг үнэн зөв тооцсон байдал;
- эрсдэлийн үнэлгээний найдвартай байдал;
- тусгай загварын дагуу тооцсон эрсдэлийн үнэлгээг бодит алдагдлын дүнтэй тухай бүр нь харьцуулж байсан эсэх талаар тусгасан байна.

5.8.5. Банк нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс хүлээж болзошгүй алдагдлыг “Хамгийн их эрсдэлийн арга”-аар тооцохын зэрэгцээ зах зээлийн хүчин зүйлд мэдрэмтгий байдлын шинжилгээг зайлшгүй хийсэн байх шаардлагатай. Үүнд банкинд их хэмжээний алдагдал учруулж болзошгүй буюу эрсдэлийн удирдлагыг алдагдуулж болзошгүй нөхцөл байдал, хүчин зүйлсийн шугаман болон шугаман бус хамаарлыг харгалзан үзнэ.

5.8.6. Банк мэдрэмтгий байдлын шинжилгээг дараахь байдлаар хийж болно:

- 13 дугаар хавсралтад заасан ханшийн өөрчлөлтийн хувь хэмжээг ашиглан;
- “Үйл ажиллагааны эрсдэлийг тооцох зөвлөмж”-д заасан экстремум хэлбэрийн тархалтаар эрсдэлийг тооцох аргуудыг ашиглан;
- математик, статистикийн бусад загварыг ашиглан

5.9. Зах зээлийн эрсдэлийг тооцох программ хангамж нь дараахь тоон шалгуурыг хангасан байна:

5.9.1. VaR, ахиуц VaR, өсөн нэмэгдэх VaR, хүчин зүйлийн VaR-ыг өдөр тутам тооцох чадвартай;

5.9.2. “Хамгийн их эрсдэлийн арга”-аар тооцоолсон алдагдал хүлээх магадлал нь 99 хувьтай байх, үүнд хэвийн тархалттай санамсаргүй хэмжигдэхүүний нягтын функцийг ашигладаг;

5.9.3. "VaR"-ын дүнг ажлын 10 өдрийн хугацаанд гарч болзошгүй ханшийн

хэлбэлзлээр тооцдог. Хэрэв хугацаа нь 10 өдрөөс бага байх шаардлагатай бол хугацааг квадрат язгуураар тэгшитгэх ба банк нь энэхүү аргаар тооцох зөвшөөрлийг Монголбанкнаас авна. Энэхүү тооцооллыг ашиглах зөвшөөрөл авсан банк нь тооцооллын бодит байдлыг Монголбанкны хяналт шалгалтын газраар жилд нэг удаа хянуулна.

5.9.4. Ханшийн хэлбэлзлийг тооцохдоо түүврийн аргыг ашиглах бөгөөд дор хаяж 250 бие даасан ажиглалт буюу таван жилийн үзүүлэлтийг хамруулдаг. (Жигнэсэн дундажийн болон бусад аргыг ашиглаж байгаа банкуудын хувьд жигнэсэн дундаж хугацааны хоорондын зай нь 6 сараас багагүй байна. Ханшийн хэлбэлзэл өндөр байх үед хяналт шалгалтын байгууллага нь хэлбэлзлийг тооцох хугацааг дээр заасан хугацаанаас багаар тогтоож болно).

5.9.5. Холбогдох мэдээллийн баазыг нэг сар тутамд шинэчлэх ба шаардлагатай тохиолдолд үүнээс бага хугацаанд шинэчлэх боломжтой байх.

5.9.6. Онцгой VaR-ыг долоо хоног бүр тооцох ба үүнийг энгийн VaR аргаар үнэлэхэд банкны тухайн үеийн нөхцөл байдалд хамгийн их алдагдал учруулж болзошгүй дараалсан 250 бие даасан ажиглалтын утгын түүхэн мэдээллийг сонгон авч, VaR загвартай ижил нөхцлөөр тооцно. Сонгосон хугацааг Монголбанкны Хяналт шалгалтын газар улирал бүр хянана.

5.10. Зах зээлийн эрсдэлийг тооцох загварыг хэрэглэх зөвшөөрөл Монголбанкнаас авахын тулд хэлбэлзэл, “варианс-коварианс”, “цаг хугацаа”, “Монте-Карло” болон тухайн сонгосон загвараар эрсдэлийг тооцоолон, энэхүү журамд заасан бусад шаардлага нөхцлийг нэг жилийн хугацаанд хангасны үндсэн дээр хүсэлт гаргана. Монголбанкны Хяналт шалгалтын газар банкны хэрэглэсэн загварыг 11 дүгээр хавсралтад заасан буцаан шалгалтын аргаар шалган, энэхүү журамд заасан бусад холбогдох шаардлага хангагдсан нөхцөлд тухайн загварыг ашиглах зөвшөөрлийг олгоно.

5.11. Банк нь төрөл бүрийн эрсдэлийн хоорондын хамаарлыг загварт оруулан тооцох эсэх асуудлыг Монголбанкны Хяналт шалгалтын газрын зөвшөөрөлтэйгээр шийдвэрлэнэ.

5.12. Энэхүү журмын 2.7.7-д заасан эрсдэлээр жигнэсэн активт нэмэгдэх гүйлгээг тооцохдоо өмнөх өдрийн "VaR" эсвэл өмнөх 60 өдрийн "VaR"-ын дундажийг үржүүлэгчээр үржүүлсэн дүнгийн аль их дээр хамгийн сүүлд тооцсон онцгой VaR эсвэл өмнөх 60 өдөр тооцсон онцгой VaR-ын дундажийг онцгой үржүүлэгчээр үржүүлсэн дүнгийн аль ихийг нэмж тооцно. Энэхүү үржүүлэгчийн дүнг буцаан шалгалтын дүнг үндэслэн 11 дүгээр хавсралтын дагуу тогтоох ба онцгой үржүүлэгчийн дүнг загварын үр дүнд үндэслэн Монголбанкны хяналт шалгалтын газраас 3-аас 4-ийн хооронд байхаар тогтооно.

5.13. Банк “Хамгийн их эрсдэлийн арга”-ын дагуу тооцсон эрсдэлийн үнэлгээг бодит алдагдлын дүнтэй харьцуулсан судалгааг сар бүр, мэдрэмтгий байдлын шинжилгээний дүнг улирал бүр Хяналт шалгалтын газарт ирүүлж байна.

5.14. Монголбанк зах зээлд онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзэн, банкнаас шаардсан нөхцөлд мэдрэмтгий байдлын шинжилгээг хийж, үр дүнг Монголбанкны Хяналт шалгалтын газарт ирүүлнэ.

ЗУРГАА. Үндсэн хөрөнгийн үзүүлэлт

6.1. Банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг үндсэн үйл ажиллагаа болох зээл олголтод ашиглах явдлыг дэмжих зорилгоор банкны үндсэн хөрөнгийн үзүүлэлтийн хязгаарлалтыг тогтооно.

6.2. Банкны үндсэн хөрөнгийн дүнг нийт активт харьцуулж үндсэн хөрөнгийн үзүүлэлтийг тооцно. Үндсэн хөрөнгийн харьцаа нь 8 хувиас дээшгүй байна.

ДОЛОО. Бусад

7.1. Банкны үйл ажиллагаанд мөрдөгдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд Монголбанкны Хяналт шалгалтын газар хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авна.

7.2. Банк нь дор дурдсан тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанкны Хяналт шалгалтын газарт бичгээр болон файлаар ирүүлнэ:

7.2.1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн тайлан /1 дүгээр хавсралт/;

7.2.2. Банкны том зээлдэгчид олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан /2 дугаар хавсралт/;

7.2.3. Банкны хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан /3 дугаар хавсралт/;

7.2.4. Банкны тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа батлан даалт, аккредитив, бусад хүлээж болзошгүй үүргийн тайлан /4 дүгээр хавсралт/;

7.2.5. Актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны тайлан /5 дугаар хавсралт/;

7.2.6. Санхүүгийн авлага, өглөгийн мөнгөн урсгалын тайлан /6 дугаар хавсралт/.

7.2.7. Гадаад валютын эрсдэлийн тайланг тухайн сарын өдөр бүрээр /7 дугаар хавсралт/;

7.2.8. Банкны ерөнхий мэдээлэл /8 дугаар хавсралт/;

7.2.9. Гадаад улсаас авах авлагын тайлан /9 дүгээр хавсралт/.

7.2.10. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны тайлан /хавсралт 14/

/МБЕ-ийн 2011 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 213 дугаар тушаалаар нэмсэн./

7.3 Гадаад валютын эрсдлийн тайланг /7 дугаар хавсралт/ Монголбанкны Валют, эдийн засгийн газарт өдөр бүр файлаар ирүүлнэ.

7.4. Энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд банкны тухай хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

----- ооОоо -----

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур
үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын Хавсралт 1

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Тэнцлийн дүн	Жин	Эрсдэл даах чадвартай өөрийн хөрөнгөөр зөвшөөрөх дүн	
A	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ /AI+AII/	0.00	xxxxx	0.00	
I	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /1+2+...+9-10/	0.00	xxxxx	0.00	
1	Хувьцаат капитал /ердийн хувьцаа/	0.00	100%	0.00	
2	Халаасны хувьцаа	0.00	100%	0.00	
3	Нөөцийн сан	0.00	100%	0.00	
4	Тухайн жилийн ашиг, алдагдал	0.00	100%	0.00	
5	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал	0.00	100%	0.00	
8	Нэмж төлөгдсөн хувьцаа (ердийн хувьцаа)	0.00	100%	0.00	
9	Хандивын капитал	0.00	100%	0.00	
10	Тохируулгын нэмэгдэх хасагдах	xxxxx	xxxxx	0.00	
II	2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө /11+12+...19-20/	0.00	100%	0.00	
11	Хувьцаат капитал /давуу эрхтэй хувьцаа/	0.00	100%	0.00	
12	Нэмж төлөгдсөн хувьцаа (давуу эрхтэй хувьцаа)	0.00	100%	0.00	
13	Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	100%	0.00	
14	Хоёрдогч өглөг /5-аас дээш жилийн хугацаатай/	0.00	100%	0.00	
15	Нийгмийн хөгжлийн сан	0.00	100%	0.00	
16	Бусад	0.00	0%	0.00	
18	Ерөнхий эрсдэлийн сан	0.00	100%	0.00	
19	Тохируулгын нэмэгдэх хасагдах	xxxxx	xxxxx	0.00	
	ЭРСДЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВ /I+II+III+IV/	Активын дүн	Эрсдэлийн сан (Сөрөг утгатай)	Эрсдэлийн жин (%)	Эрсдлээр жигнэсэн активын дүн
I	Тэнцлийн үзүүлэлт	0.00	0.00	xxxxx	0.00
1	Бэлэн мөнгө	0.00	xxxxx	0%	0.00
2	Замд яваа мөнгө	0.00	xxxxx	20%	0.00
3	Төв банкин дахь харилцах, хадгаламж, репо, хүүгийн авлага	0.00	xxxxx	0%	0.00
4	Монгол Улсын Хөгжлийн банк, дотоодын банкнаас авах төгрөгийн авлага /3 сараас доош хугацаатай/	0.00		20%	0.00
5	Монгол Улсын Хөгжлийн банкнаас авах төгрөгийн авлага /3 жилээс дээш хугацаатай/			20%	0.00
6	Монгол Улсын Хөгжлийн банк, дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авах бусад авлага	0.00		100%	0.00
7	Үнэт металл	0.00	0.00	100%	0.00
8	Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авах авлага	0.00	0.00	xxxxx	0.00
	8.1 20%-иар жигнэгдэх			20%	0.00
	8.2 50%-иар жигнэгдэх			50%	0.00
	8.3 100%-иар жигнэгдэх			100%	0.00
	8.4 150%-иар жигнэгдэх			150%	0.00
9	Монголбанкны үнэт цаас, хүүгийн авлага	0.00		0%	0.00
10	Засгийн газрын үнэт цаас, хүүгийн авлага, Засгийн газрын баталгаатай үнэт цаас	0.00	0.00	xxxxx	0.00
	10.1 Засгийн газрын үнэт цаас, хүүгийн авлага,	0.00		0%	0.00
	10.2 Засгийн газрын баталгаатай үнэт цаас (хүүгийн авлага орохгүй)			0%	0.00
	10.3 Засгийн газрын бусад үнэт цаас (хүүгийн авлага орохгүй)			0%	0.00
11	Бусад үнэт цаас, хөрөнгө оруулалт	0.00	0.00	xxxxx	0.00
	11.1 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас			100%	0.00
	11.2 Ипотекийн зээлээр баталгаажсан бонд /ИЗББ/			50%	0.00
	11.3 Бусад үнэт цаас (Вексел, хувьцаа, өрийн бичиг)			100%	0.00

12	Гадаадын үнэт цаас	0.00	0.00	xxxxx	0.00
	12.1 20%-иар жигнэгдэх			20%	0.00
	12.2 50%-иар жигнэгдэх			50%	0.00
	12.3 100%-иар жигнэгдэх			100%	0.00
	12.4 150%-иар жигнэгдэх			150%	0.00
13	Хараат, охин, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт			100%	0.00
14	Зээлийн өрийн үлдэгдэл	0.00	0.00	xxxxx	0.00
	14.1.Гадаадын банкнаас гаргасан батлан даалтаар баталгаажсан зээл	0.00	0.00	xxxxx	0.00
	14.1.1 20%-иар жигнэгдэх			20%	0.00
	14.1.2 50%-иар жигнэгдэх			50%	0.00
	14.1.3 120%-иар жигнэгдэх			100%	0.00
	14.1.4 150%-иар жигнэгдэх			150%	0.00
	14.5. Иргэнд төгрөгөөр олгосон орон сууцны ипотекийн зээл			50%	0.00
	14.6. Иргэнд гадаад валютаар олгосон орон сууцны ипотекийн зээл			100%	0.00
	14.6 Дэд хөтөлбөрүүдийн зээл			0%	0.00
	14.7. Барилга, боловсруулах үйлдвэр, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны зээл			70%	0.00
	14.8. Ханшийн эрсдэлтэй иргэд, аж ахуй нэгжид олгосон гадаад валютын бусад зээл			120%	0.00
	14.9. Хадгаламж барьцаалсан зээл			0%	0.00
	14.10.Бусад зээл	0.00	0.00	100%	0.00
	14.11.Зээлийн хойшлогдсон төлбөр	0.00	xxxxx	100%	0.00
	14.12.Зээлийн бодит үнийн залруулга	0.00	xxxxx	0%	0.00
	14.13.Хамтын зээлээс бусад банкны хүлээх эрсдэлийн дүн	0.00	xxxxx	100%	0.00
15	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	0.00	xxxxx	100%	0.00
16	Санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө	0.00	xxxxx	100%	0.00
17	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	0.00	xxxxx	100%	0.00
18	Дериватив санхүүгийн хөрөнгө	0.00	xxxxx	100%	0.00
	18.1 Монголбанкттай хийсэн	0.00	xxxxx	0%	0.00
	18.2 Бусад	0.00	xxxxx	100%	0.00
<i>/18дахь хэсгийг МБЕ 2018.08.03-ны өдрийн А-215 дугаар тушаалаар өөрчлөн найруулсан/</i>					
II	Тэнцлийн гадуурх үзүүлэлт	0.00	xxxxx	xxxxx	0.00
1	Деривативын зээлтэй адилтган тооцох өртөг		xxxxx	100%	0.00
2	Аккредитивууд (эх үүсвэрээр цэвэршүүлсэн)	0.00	xxxxx	20%	0.00
	а/ Аккредитивууд	0.00	xxxxx	xxxxx	xxxxx
	б/ Аккредитивын эх үүсвэр		xxxxx	xxxxx	xxxxx
3	Батлан даалт, баталгаа (эх үүсвэрээр цэвэршүүлсэн)	0.00	xxxxx	100%	0.00
	а/ Батлан даалт, баталгаа	0.00	xxxxx	xxxxx	xxxxx
	б/ Батлан даалт, баталгааны эх үүсвэр, Дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанкинд гаргасан		xxxxx	xxxxx	xxxxx
4	Тендер болон гүйцэтгэлийн батлан даалт (эх үүсвэрээр цэвэршүүлсэн)	0.00	xxxxx	50%	0.00
	а/ Батлан даалт	0.00	xxxxx	xxxxx	
	б/ Батлан даалтын эх үүсвэр		xxxxx	xxxxx	
5	Зээлийн шугам	0.00	xxxxx	50%	0.00
6	Хамтын санхүүжилттэй зээлийн эрсдэлд харгалзах зээлийн цэвэр үлдэгдэл	0.00	xxxxx	100%	0.00
7	Бусад хүлээж болох үүрэг	0.00	xxxxx	50%	0.00
III	Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт	0.00	xxxxx	xxxxx	0.00
IV	Сүүлийн гурван жилийн эерэг ашгийн дундаж		xxxxx	xxxxx	0.00

/Энэхүү хавсралтыг МБЕ-ийн 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А-243 дугаар тушаалаар шинэчлэн баталсан./

САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВИЙН ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ ӨРТГИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

1. Санхүүгийн деривативийн зээлтэй адилтган тооцох өртгийг энэхүү аргачлалын дагуу тодорхойлно.

2. Зээлтэй адилтган тооцох өртгийг дараахь деривативийн хувьд тооцно:

2.1. Хүүгийн эрсдэлийн деривативууд:

2.1.1. Тухайн нэг улс, орны валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгслүүдийн хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Single currency interest rate swaps),

2.1.2. Санхүүгийн хэрэгслүүдийн суурь хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Basis swaps),

2.1.3. Хүүгийн форвардын гэрээ, хэлцэл (Forward rate agreement),

2.1.4. Худалдан авсан хүүгийн опцион гэрээ, хэлцэл. Үүнд хүүгийн дээд болон доод хязгаарыг тогтоосон, мөн эдгээрийг хослуулан хэрэглэсэн гэрээ, хэлцэл хамаарна (Interest rate options purchased, including caps, collars and floors purchased),

2.2. Гадаад валютын арилжааны дериватив:

2.2.1. Хоёр өөр улс орны валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн бүтээгдэхүүний хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Cross-currency interest rate swaps),

2.2.2. Гадаад валютын арилжааны форвардын гэрээ, хэлцэл (Forward foreign exchange contracts),

2.2.3. Бусдаас худалдан авсан гадаад валютын арилжааны опцион гэрээ, хэлцэл (Currency options purchased),

2.3. Зээлийн эрсдэл үүсгэж болзошгүй санхүүгийн бусад дериватив.

3. Энэхүү аргачлалын 2 дугаар зүйлд заасан деривативийн ангилалд хамаарах боловч дараахь шинж чанарыг агуулсан деривативийн хувьд зээлтэй адилтган тооцох өртгийг тооцох шаардлагагүй:

3.1. Хугацаа нь 14 өдрөөс доош;

3.2. Тусгай зориулалт бүхий дотоодын бирж дээр арилжаалдаг, үнэ ханшийн зөрүүнээс үүдэлтэй аливаа төлбөр тооцоог өдөрт нь тусгай клирингийн төвөөр дамжуулан гүйцэтгэдэг дериватив.

4. Санхүүгийн деривативийн зээлтэй адилтган тооцох өртгийг (credit equivalent amount) тухайн үеийн (current exposure) болон ирээдүйд хүлээж болзошгүй (potential future credit exposure) алдагдлын нийлбэр дүнгээр тодорхойлно.

5. Тухайн үеийн алдагдлын дүнг санхүүгийн деривативийн суурь бүтээгдэхүүний гэрээнд заасан үнэ болон тухайн үеийн зах зээлийн үнэ хоёрын зөрүүгээр тооцох бөгөөд шаардлагатай үед хүү, ханш, индекс болон харилцагч этгээдийн төлбөрийн чадварт гарсан өөрчлөлтийг харгалзан үзэж болно.

6. Ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын дүнг санхүүгийн деривативийн суурь бүтээгдэхүүний гэрээнд заасан үнийг Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос баталсан хөрвүүлэлтийн хувь хэмжээгээр (conversion factor) үржүүлэн тооцно:

Төлөгдөх хугацаа	Хүүгийн эрсдэлийн	Гадаад валютын болон алтны арилжааны	Хувьцааны арилжааны	Алтнаас бусад үнэт металлын	Бусад
1 жилээс доош хугацаатай	0.0%	1.0%	6.0%	7.0%	10.0%
1-5 жилийн хугацаатай	0.5%	5.0%	8.0%	7.0%	12.0%
5 жилээс дээш хугацаатай	1.5%	7.5%	10.0%	8.0%	15.0%

7. Деривативийн ашиг алдагдлыг цэвэршүүлэн тооцох бололцоотой бол зээлтэй адилтган тооцох өртгийг дараахь томъёог ашиглан бодож гаргана:

$$A_{Net} = 0.4 \times A_{Gross} + 0.6 \times NGR \times A_{Gross}$$

A_{net} - зээлтэй адилтган тооцох цэвэр өртөг

A_{gross} - зээлтэй адилтган тооцох нийт өртөг

NGR - ашиг, алдагдлын нийлбэр дүнг тухайн үеийн алдагдлын нийлбэр дүнд харьцуулсан харьцаа. Үүнд ашиг, алдагдлын нийлбэр дүн нь тэгтэй тэнцүү, аль эсвэл сөрөг утгатай байвал NGR-ийг тэгтэй тэнцүү гэж үзнэ.

ЖИШЭЭ:

"А" банк нь 3 сарын хугацаатай, 5000.0 мянган ам.долларын гадаад валютын форвардын гэрээ; 4 жилийн хугацаатай, 6000.0 мянган ам.долларын суурь хүүгийн свопын гэрээ; 6 жилийн хугацаатай, 12000.0 мянган ам.долларын хувьцааны арилжааны фьючерсийн гэрээ тус тус байгуулсан байсан бөгөөд 2004 оны 4 дүгээр сарын байдлаар деривативуудыг зах зээлийн үнэлгээгээр нь үнэлэхэд гадаад валютын арилжааны гэрээнээс 20.0 мянган ам.долларын, хувьцааны арилжааны фьючерсийн гэрээнээс 100.0 мянган ам.долларын алдагдал тус тус хүлээж, харин хүүгийн свопоос 10.0 мянган ам.долларын ашиг олсон байв.

"А" банкны зээлтэй адилтган тооцох нийт өртгийг тооцоход:

2004 оны 4 дүгээр сарын байдлаар (мянган ам.доллар)

	СУУРЬ	ХӨРВҮҮЛЭЛ-	ИРЭЭДҮЙД	ТУХАЙН	ЗЭЭЛТЭЙ
САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВ					

		бүтээгдэх- үүний үнэ	тийн хувь хэмжээ	хүлээж болзошгүй алдагдал	үеийн алдагдал	адилтган тооцох өртөг (нийт)
	А	1	2	3=1*2	4	5=3+(4>0)
1	3 сарын хугацаатай гадаад валютын форвардын гэрээ	5 000,0	1,0%	50,0	20,0	70,0
2	4 жилийн хугацаатай суурь хүүгийн своп	6 000,0	0,5%	30,0	0,0	30,0*
3	6 жилийн хувьцааны арилжааны фьючерсийн гэрээ	12 000,0	10,0%	1 200,0	100,0	1300,0
	БҮГД	23 000,0		1 280,0	120,0	1400,0

Тайлбар: * - зээлтэй адилтган тооцох өртгийг тооцоходоо ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын дүнг тухайн үеийн ашгийн дүнгээр хорогдуулахгүй.

Хүснэгтээс үзэхэд 3 деривативийн гэрээнийн зээлтэй адилтган тооцох нийт өртөг нь 1400.0 мянган ам.доллар байна. Хүүгийн свопын ашгийг харгалзан зээлтэй адилтган тооцох өртгийг тооцвол:

$$A_{Net} = 0.4 \times 1400.0 + 0.6 \times \left(\frac{20.0 - 10.0 + 100.0}{20.0 + 100.0} \right) \times 1400.0 = 1330.0$$

ЖИШЭЭ I

"А" банкны тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансдын үлдэгдэл дараахь байдалтай байв.

	Ам.Доллар	Дойч марк	Британийн фунт	БҮГД
ТЭНЦЛИЙН ДАНС	275,0	-365,0	65,0	-25,0
Актив	3 005,0	665,0	115,0	3 785,0
Касс дахь бэлэн валют	120,0	50,0	10,0	180,0
Чек	50,0	145,0	5,0	200,0
Гадаадын банкин дахь хар-х, хад-мж	890,0	50,0	0,0	940,0
Гадаад валютаар олгосон зээл (цэвэр)	1 870,0	420,0	100,0	2 390,0
Алт	75,0	0,0	0,0	75,0
Пассив	2 730,0	1 030,0	50,0	3 810,0
Гадаад валютын харилцах	2 000,0	150,0	50,0	2 200,0
Гадаад валютын хадгаламж	550,0	220,0	0,0	770,0
Гадаадын банкны хар-х, хад-мж	180,0	0,0	0,0	180,0
Гадаадын банкнаас авсан зээл	0,0	660,0	0,0	660,0
ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС	1 080,0	270,0	-550,0	800,0
Батлан даалт аккредитив	520,0	200,0	0,0	720,0
Батлан даалт	400,0	200,0	0,0	600,0
Аккредитив	120,0	0,0	0,0	120,0
Санхүүгийн деривативууд	-140,0	670,0	0,0	530,0
Форвардын хэлцэл	0,0	185,0	0,0	185,0
Фьючерсийн хэлцэл	0,0	485,0	0,0	485,0
Своп хэлцэл	-140,0	0,0	0,0	-140,0
Гадаад валютын арилжааны опцион	700,0	-600,0	-550,0	-450,0
Опцион (call)	700,0	0,0	0,0	700,0
Опцион (put)	0,0	-600,0	-550,0	-1 150,0

1/ Нэг валютын хувьд цэвэр спот позицийг (журмын 6.3-ын 1/-ээс үзнэ үү) тэнцлийн гадаад валютын актив пассивын зөрүүгээр тооцно. Үүнд ам.долларын хувьд:

$$A1 = (120+50+890+1870+75) - (2000+550+180) = 275$$

2/ Цэвэр спот позицийг тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа өглөг, авлагын дүнгээр (журмын 6.3-ын 2/-оос үзнэ үү) тохируулна.

$$A2 = 275-140 = 135$$

3/ Гарсан дүнг тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа төгрөгийн эх үүсвэртэй батлан даалт, аккредитивын дүнгээр (журмын 6.3-ын 3/-аас үзнэ үү) тохируулна.

$$A3 = 135 - 400 - 120 = -385$$

Тайлбар: Гадаадын банкнаас авах цэвэр авлагын дүн [890-180=710] батлан даалт, аккредитивын дүнгээс [520=400+120] их байгаа тул шууд хасалт хийсэн болно.

4/ Эцсийн шатанд гадаад валютын опционы дүнгээр (журмын 6.3-ын 5/-аас үзнэ үү) тохируулга хийнэ. (Үүнд холбогдох арилжааны дүнг опционы дельта [манай жишээнд 0.5419]-аар үржүүлнэ):

$$A4 = -385 + 700 * 0.5419 = - 5.67 \approx - 6$$

Тайлбар: Гадаад валютын опционы "дельта" суурьтай өртөгийг Гармэн-Колхаген ("Garman-Kohlhagen")-ны томъёогоор тооцно:

$$C = e^{-FT} SN(x + \sigma\sqrt{T}) - e^{-DT} KN(x)$$

$$x = \frac{\ln(S/K) + (D - F - \sigma^2/2)T}{\sigma\sqrt{T}}$$

$$delta = \frac{\partial C}{\partial S} = e^{-FT} N(x + \sigma\sqrt{T}) > 0$$

Үүнд "С" нь колл опционы өртөг, "F" нь гадаад валютын хүү, "D" нь үндэсний валютын хүү, "T" нь опционы хугацаа, "S" нь спот ханш, "K" нь опционы гэрээнд заасан ханш, N(x) нь спот болон гэрээнд заасны ханшны харьцааг хүүгийн зөрүү болон опционы хугацаагаар тохируулсан дүн нь тодорхой тоон утгатай тэнцүү буюу түүнээс бага байх магадлал. Энэхүү магадлалыг хэвийн тархалттай санамсаргүй хэмжигдэхүүний нягтын функцийн тусламжтайгаар олно.

Банкны өөрийн хөрөнгө 1700 сая төгрөг гэвэл нэг валютын хувьд зохистой харьцаа (журмын 6.3-аас үзнэ үү) хасах 0.35 хувьтай байна:

$$\text{Зохистой харьцаа (USD)} = - 6 / 1700 = - 0.35 \%$$

Энэхүү аргачлалын дагуу бусад гадаад валютын хувьд цэвэр зөрүүг тооцож, дундажийн аргаар нийт гадаад валютын актив пассивын зөрүүг тодорхойлоход дараахь байдалтай байна.

Актив пассивын цэвэр зөрүү	-6,0	245,0	65,0
Урт, богино позицийн нийлбэр	-6,0	310,0	
Нийт гадаад валютын актив, пассивын зөрүү	310,0		

Үүнд өөрийн хөрөнгө 1700 сая төгрөг байгаа нийт гадаад валютын хувьд зохистой харьцаа (журмын 6.2, 6.6 ба 6.7-оос үзнэ үү) 18 хувьтай байна:

$$\text{Зохистой харьцаа (Нийт)} = 310 / 1700 = 18 \%$$

ЖИШЭЭ 2

Нийт гадаад валютын эрсдэлийг тооцохдоо нийт нээлттэй позицийг өөрийн хөрөнгөд харьцуулж тооцно. Нийт нээлттэй позицийг тооцохдоо дундажийн аргыг ашиглана.

ГАДААД ВАЛЮТЫН ПОЗИЦИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

	Нийт валют	USD	EUR	JPY	GBP	CNY	
ГАДААД АКТИВ	28,585	22,167	2,125	420	2,196	1,677	
Касс дахь бэлэн мөнгө	192	115	0	67	10	0	
Төв банкин дахь харилцах хадгаламж	1,083	758	54	108	76	87	
Гадаадын банкин дахь харилцах хадгаламж	245	0	0	0	245	0	
Дотоодын банкин дахь харилцах хадгаламж	24,504	19,604	1,960	245	1,715	980	
Гадаадын үнэт цаас	772	772	0	0	0	0	
Гадаад валютаар олгосон зээл	200	40	0	0	60	100	
Бусад гадаад валютын авлага	687	652	21	0	0	14	
Бусад	902	226	90	0	90	496	
ГАДААД ПАССИВ	15,006	2,616	9,159	2,033	462	736	
Гадаад валютын харилцах	5,460	1,638	2,184	819	273	546	
Гадаад валютын хадгаламж	1,000	0	1,000	0	0	0	
Батлан даалт аккредитивын эх үүсвэр	5,977	897	3,586	1,195	120	179	
Гадаад валютаар авсан зээл	2,348	0	2,348	0	0	0	
Төслийн зээлийн санхүүжилт	34	34	0	0	0	0	
Бусад гадаад валютын өглөг	187	47	41	19	69	11	
Актив пассивын цэвэр зөрүү	13,579	19,551	-7,034	-1,613	1,734	941	
Урт позици		19,551			1734	941	22,226
Богино позици			7034	1613			8,647

А банкны гадаад валютын позицийн тайланг дээрх хүснэгтэд харууллаа. Валют тус бүрийн хувьд актив пассивын зөрүүг тооцно. Эндээс нийт урт болон нийт богино позицийг тооцно:

Нийт урт позиц = $19,551 + 1,734 + 941 = 22,226$

Нийт богино позиц = $7,034 + 1,613 = 8,647$

Нийт нээлттэй позиц = $\max(\text{нийт урт позиц}, \text{нийт богино позиц}) = 22,226$

ХАМГИЙН ИХ ЭРСДЭЛИЙН АРГЫН БУЦААН ШАЛГАЛТ

Бүс	Тооцсон алдагдал бодит дүнгээс хэтэрсэн тоо	Үржүүлэгч	Өсөн нэмэгдэх магадлал
Ногоон Бүс	0	3.00	8.11%
	1	3.00	28.58%
	2	3.00	54.32%
	3	3.00	75.81%
	4	3.00	89.22%
Шар Бүс	5	3.40	95.88%
	6	3.50	98.63%
	7	3.65	99.60%
	8	3.75	99.89%
	9	3.85	99.97%
Улаан бүс	10 буюу түүнээс дээш	4.00	99.99%

Хүснэгтэд зах зээлийн эрсдэлийг дотоод загварын аргаар тооцох үед загварыг буцааж шалгахад ашиглах ногоон, шар, улаан бүсийг тодорхойлов. Дээрх хязгаарууд нь 250 ажиглалттай үед ашиглагдах бөгөөд ажиглалтын тоо 250-аас ялгаатай үед шар бүс өсөн нэмэгдэх магадлал 95 хувиас багагүй байх утгад харгалзах бөгөөд улаан бүс өсөн нэмэгдэх магадлал 99.99 хувиас багагүй байх утгад харгалзана.

Өсөн нэмэгдэх магадлал нь 99 хувийн итгэлцлийн түвшинг ашиглаж байх үед тооцсон алдагдал бодит дүнгээс хэтэрсэн ажиглалтын тоо заасан утгаас ихгүй байх магадлалыг харуулна.

ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН МЭДРЭМТГИЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ЖИШИГ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Банк Монголбанкинд мэдээлэх мэдрэмтгий байдлын шинжилгээг Хамгийн их эрсдэлийн аргын вариаци-ковариацийн аргаар дараах ковариацийн матрицийг ашиглан тооцно:

	USD	CNY	JPY	KRW	CHF	EUR	GBP
USD	0.000851	0.000843	0.000839	0.000598	0.000828	0.000860	0.000694
CNY	0.000843	0.000843	0.000837	0.000622	0.000854	0.000888	0.000707
JPY	0.000839	0.000837	0.001632	0.000429	0.000897	0.000874	0.000453
KRW	0.000598	0.000622	0.000429	0.003949	0.001667	0.002032	0.001468
CHF	0.000828	0.000854	0.000897	0.001667	0.001854	0.001872	0.001289
EUR	0.000860	0.000888	0.000874	0.002032	0.001872	0.002223	0.001586
GBP	0.000694	0.000707	0.000453	0.001468	0.001289	0.001586	0.001984

Энэхүү жишиг нөхцөл байдлыг 1993-2009 оны валютын ханшийн мэдээнд үндэслэн банкуудад хамгийн их алдагдал учруулж болзошгүй дараалсан 250 ажлын өдрийг сонгон авч зохиосон бөгөөд сонгогдсон хугацаа нь 2008 оны 6-р сарын 13-наас 2009 оны 6-р сарын 8 хүртэл болно. Дээрх хүснэгтэд ороогүй бусад валютын хувьд ханшийн хэлбэлзлийг 20 хувиар тооцож, өмнө гарсан дүн дээр нэмж тооцно.

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 14 дүгээр хавсралт

БАНКНЫ ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

... он...сар...өдөр

(мянган төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		
А	ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ /1+2+3+4+5-6-7/	-
1	Бэлэн мөнгө	-
2	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	-
3	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-
4	Үнэт металл, Төв банкны үнэт цаас, ЗГ-ын үнэт цаас, репо үнэт цаасны нийлбэр дүн	-
5	ЗГ-ын баталгаатай Хөгжлийн банкны үнэт цаас	-
6	Банк хоорондын клирингийн тооцоны саатлын данс	-
7	Тохируулга	-
Б	БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ /1+2+3+4+5-6-7/	-
1	Харилцах	-
2	Хадгаламж	-
3	Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	-
4	Бусад эх үүсвэр	-
5	Бусад өр төлбөр	-
6	Банк хоорондын клирингийн тооцоны саатлын данс	-
7	Тохируулга	-
В	ТӨЛ.ТҮР. ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (А/Б*100)	
Г	ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25.00%
Д	ХАРЬЦААНЫ БИЕЛЭГДЭЭГҮЙ ХУВЬ /Г-В/	
Е	ШААРДЛАГАТАЙ НЭМЭЛТ ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ	-

Тайлбар: Хоёрдогч өглөгийг өр төлбөрийн дүнд оруулан тооцохгүй

Банк хоорондоор харилцан байршуулсан аливаа харилцах, хадгаламж зээлийн дүнг цэвэрлэн тооцно

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал: /нэр/
 Санхүү, бүртгэлийн газрын захирал: /нэр/
 Санхүү, бүртгэлийн газрын ажилтан: /нэр /

/Энэхүү хавсралтыг МБЕ-ийн 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 691 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан./